



**БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ХҮРЭЭМАРАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2022 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 210

Дэлгэрмөрөн

Засаг даргын нөөц хөрөнгөөс  
зарцуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт зарцуулалтын нийтлэг журам”-ийн 2.1.6 дахь заалт, сумын Засаг даргын зөвлөлийн 2022 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн 01 дүгээр хуралдааны шийдвэрийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн аварга шалгаруулах гар бөмбөгийн тэмцээнд оролцож байгаа тамирчдын хувцасны үнэ болох 990 000 (Есөн зуун ерэн мянга) төгрөг, Сумын ард иргэд, төрийн албан хаагчдыг соён гэгээрүүлэх сургалт сурталчилгааны арга хэмжээнд 432000 (Дөрвөн зуун зуун гучин хоёр мянга) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс тус тус зарцуулахыг Нягтлан бодогч (Б.Баттөмөр)-д зөвшөөрсүгэй.

2.Анхан шатны санхүүгийн баримтыг бүрдүүлж тайлан тооцоог гаргаж ажиллахыг Нярав (Ц.Ганбаатар)-д үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Д.Баярсайхан)-д даалгасугай.

ДАРГА



С.СУМЪЯАБАЗАР

Zahiramj -2022 on

642201031